



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн их сургууль (бүрэлдэхүүн сургууль, нэгж)-ийн албан хэрэгцээнд зориулан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 2024 онд нийт 1,560,297,000.00 (нэг тэрбум таван зуун жаран сая хоёр зуун ерэн долоон мянга) төгрөгт багтаан үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрч, санхүүжилтийн дүн, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хөдөө аж, ахуйн их сургуулийн ректор Б.Баасансүхэд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгө олж авах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 01 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

2.4. 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн их засварын ажлын зураг төсвийг бэлтгэн 2024 оны 3 дугаар сард багтаан танилцуулан батлуулах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001095
6-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн
87 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР
2024 ОНД ОЛЖ АВАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эргэлтийн бус хөрөнгийн төрөл, нэр	Хэмжих нэгж	Барьж эхэлсэн (эхлэх/дуусах) он	Нийт төсөвт өртөг (төгрөг)	2023 оны гүйцэтгэл (төгрөг)	2024 онд зарцуулах санхүүжилтийн дүн (төгрөг)
1. Барилга байгууламж, их засвар, өргөтгөл (өмнөх оноос)						
1	ХААИС-ЭЗБС-ийн номын сангийн барилга		2017/2024	1,500,000,000.00	250,000,000.00	779,440,000.00
2. Тоног төхөөрөмж						
1	Суурин компьютер /ком/	ш	60.00	221,400,000.00		221,400,000.00
2	Проектор	ш	10.00	30,000,000.00		30,000,000.00
3	Хувилагч	ш	20.00	20,000,000.00		20,000,000.00
4	Санхүүгийн программ хангамж	ш	4.00	31,946,000.00		31,946,000.00
5	Мал эмнэлгийн сургуулийн тоног төхөөрөмж	ш	1.00	7,000,000.00		7,000,000.00
6	Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн тоног төхөөрөмж	ш	-	70,711,000.00		70,711,000.00
7	Суурин компьютер	Ш	24.00	60,000,000.00		60,000,000.00
8	Проектор	Ш	3.00	6,900,000.00		6,900,000.00
9	Ухаалаг дэлгэц	Ш	1.00	12,000,000.00		12,000,000.00
10	Принтер	Ш	1.00	450,000.00		450,000.00
11	Зөөврийн компьютер	Ш	3.00	11,100,000.00		11,100,000.00
12	Суурин компьютер	ш	8.00	32,000,000.00		32,000,000.00
Дүн						503,507,000.00
3. Тавилга, эд хогшил, бусад үндсэн (биет бус) хөрөнгө						
1	Тавилга, эд хогшил /сандаг, ширээ/	ш	-	80,000,000.00		80,000,000.00
2	Лабораторийн вакуум	Ш	1.00	120,000,000.00		120,000,000.00
3	Тавилга, эд хогшил	Ш	1.00	20,000,000.00		20,000,000.00
4	Дотуур байр зочны байрны тавилга, эд	ш	-	7,325,000.00		7,325,000.00
5	Хөшиг тогтоогч	Ш	25.00	525,000.00		525,000.00
6	Угаалгын машин	Ш	2.00	800,000.00		800,000.00
7	Ширээ	Ш	60.00	12,000,000.00		12,000,000.00
8	Сандаг	Ш	90.00	1,800,000.00		1,800,000.00
9	Хөшиг тогтоогч	Ш	60.00	2,100,000.00		2,100,000.00
10	Ор	ш	100.00	20,000,000.00		20,000,000.00
11	Ширээ сандал	ш	16.00	9,600,000.00		9,600,000.00
12	Сурах бичиг	ш	32.00	3,200,000.00		3,200,000.00
Дүн						277,350,000.00
НИЙТ ДҮН						1,560,297,000.00 (нэг тэрбум таван зуун жаран сая хоёр зуун ерэн долоон мянга) төгрөг